

ЯПОН УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ж.КОИЗҮМИГИЙН МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ

*У.Загдцэсэм**

Энэ 2006 он бол Монгол Улсын түүхэнд онцгой жил юм. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг манай оронд төдийгүй НҮБ-ын хэмжээнд, олон улсын хэмжээнд хүндэтгэлтэйгээр тэмдэглэж байгаатай холбогдон дэлхийн нэрт улс төрчид, алдар суутнууд, хүндэт зочид манай улсад айлчлан ирсээр байгаа билээ. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд Миеэгомбын Энхболдын урилгаар Япон улсын Засгийн газрын Ерөнхий сайд Жүничиро Коизүми 2006 оны наймдугаар сарын 10-11-нд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь Монгол, Японы харилцааны хөгжилд ихээхэн ач холбогдол бүхий том үйл явдал боллоо. Япон улс бол манай улсын гадаад харилцаанд гол чухал байр суурийг эзэлдэг, манай ардчилал, эдийн засгийн шинэчлэлтийг эхнээс нь тууштай дэмжсээр байгаа хамгийн том хандивлагч орон билээ. Япон Улсын Засгийн газрын Ерөнхий сайд Т.Кайфу 1991 оны наймдугаар сард, К.Обүчи 1999 оны долдугаар сард манай улсад албан ёсны айлчлал хийсэн билээ. Ерөнхий сайд Ж.Коизүмигийн айлчлал нь Япон улсын Засгийн газрын тэргүүний манай улсад хийж буй гурав дахь удаагийн айлчлал юм.

Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн төрийн зочин Ерөнхий сайд Жүничиро Коизүмиг Монголын төр, ард түмэн халуун дотноор хүлээн авсан. Ерөнхий сайд Жүничиро Коизүми Монголын ард түмэнд Их Монгол улсын 800 жилийн ойн баярыг хүргэв. Чингис хаан, түүний байгуулсан Их Монгол улсын дэлхийн түүх, соёлд оруулсан хувь нэмрийг Ерөнхий сайд Ж.Коизүми бишрэн хүндэтгэж явдгаа дурдаад уг ойг Япон улсад “Монголын жил” болгон тэмдэглэж байгааг хэлэв. Тэрээ оюутан ахуй цагаасаа Чингис хааны тухай ном зохиол цуглуулж уншдаг байсан, одоо Японы “Никкэй” сонинд өдөр бүр цувралаар нийтлэгдэж байгаа “Чингис хаан” романыг шимтэн уншдаг ажээ. Ерөнхий сайд Ж.Коизүми Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлж “Чингис хаан” дуурийг үзэж сонирхов. Их Монгол улсын нийслэл Хархорины музей байгуулахад зориулж 2.9 тэрбум төгрөгийн тусламжийг бэлэглэж байгаагаа мэдэгдсэн юм.

* У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистрант

Тэрээр Японы улс төрд нилээд өөрчлөлт шинэчлэлтийг хийсэн ард түмнийхээ дунд нэр хүндтэй улс төрчийн нэг бөгөөд өвөө нь Япон улсын Шуудан холбооны сайд, эцэг нь Батлан хамгаалахын сайдын албыг хашиж байжээ. Түүний талаар товч танилцуулахад: 1942 оны 1-р сарын 8-нд Канагава мужид төрсөн. 1967 онд Японы Кэйо их сургуулийн эдийн засгийн ангийг төгсөөд Лондонгийн их сургуульд үргэлжлэн суралцсан. 1972 онд Японы Парламентын төлөөлөгчдийн танхимын гишүүнээр сонгогдож, 1979 онд Сангийн яамны нарийн бичгийн дарга, 1980 онд ЛАН-ын санхүүгийн хорооны дарга, 1986 онд Төлөөлөгчдийн танхимын санхүүгийн хорооны дарга, 1987 онд ЛАН-ын дотоод асуудал эрхэлсэн хорооны тэргүүн, 1988 онд Эрүүл мэндийн сайд, 1989 онд ЛАН-ын эрүүл мэндийн бодлого төлөвлөлт судалгааны хорооны дарга, 1990 онд ЛАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, 1991 онд Шуудан цахилгаан холбооны сайд, 1996-1997 онуудад Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, 2001 оноос эрх баригч ЛАН-ын дарга, Япон улсын Засгийн газрын Ерөнхий сайдын албыг тус тус хашиж, 2006 оны 9-р сарын 26-нд бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон юм.

Ерөнхий сайд Ж.Коизүми энэ удаа манай улсад 2 дахь удаагаа айлчилж байгаа бөгөөд 1997 онд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд байхдаа айлчилж байжээ.

Энэ удаагийн айлчлалын зорилгыг Японы тал:

1. Их Монгол улсын 800 жилийн ойд Японы Засгийн газрын дээд хүндэтгэлийг үзүүлж, баяр хүргэх,
2. Японы гадаад бодлогод Монгол Улсын ач холбогдол, байр суурь өсөж байгааг харуулах,
3. Монголын ардчилал, шинэчлэлтийг Япон улс цаашид ч дэмжихээ нотлох,
4. Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхий сайд М.Энхболд нартай тогтоосон харилцаагаа улам ойр дотно болгох гэж тодорхойлсон.

Манай тал: Монгол, Японы харилцааны өнөөгийн найрсаг уур амьсгал, өндөр түвшнийг бататгаж, шинэ шатанд гарч байгаа иж бүрэн түншлэлийг хэрэгжүүлэх зорилт, арга замыг тодорхойлж тохиролцох зорилго тавьсан бөгөөд хоёр талын тавьсан зорилго бүрэн биелснийг хоёр тал санал нэгтэй тэмдэглэсэн юм.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд, Япон улсын Ерөнхий сайд Ж.Коизүми нар хэлэлцээ хийв.

Ерөнхий сайд М.Энхболд Япон улстай харилцаагаа бэхжүүлэх зорилт нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг гэдгийг нотлоод өнгөрсөн гуравдугаар сард Японд айлчлах үеэрээ Монгол, Японы иж бүрэн түншлэлийг шинэ шатанд гаргахаар тохиролцсоны үндсэн дээр түүнийг хэрэгжүүлэх 10 жилийн хөтөлбөр боловсруулах санал тавив. Ерөнхий сайд Ж.Коизүми энэ саналыг хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тустай санал байна гэдгийг тэмдэглэсэн юм.

Ерөнхий сайд нар иж бүрэн түншлэлийн шинэ шатны зорилт нь хоёр орны харилцааны өндөр төвшнийг хадгалж, итгэмжилсэн байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн харилцан ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэх, боловсрол соёл хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөтгөх, олон улсын талбар дахь бие биеийг дэмжсэн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд чиглэж байгааг харилцан нотлосон юм.

Ерөнхий сайд Ж.Коизүми Монгол Улс бол Япон Улсын чухал түнш гэдгийг тэмдэглээд Японы гадаад бодлого дахь Монгол Улсын ач холбогдол өсч байгааг онцлон дурдав. Геополитикийн онцлог байрлалтай Монгол Улс ардчиллын замаар тууштай урагшилж, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж байгаагаараа бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлд хувь нэмэр оруулж байна гэж үнэлэв. Мөн Монгол Улс ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн тэнцвэртэй харилцаатай, БНАСАУ-тай уламжлалт найрсаг харилцаатай, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын ажиглагч гэх мэт Японд байхгүй давуу тал байгааг тэмдэглэж байв.

Монголын ардчилсан шинэчлэлтийг Япон улс цаашид ч идэвхитэй дэмжиж, Монгол орны тулгамдсан асуудлууд, урт удаан хугацааны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд тусалж, хамтран ажиллахаа илэрхийллээ.

Ерөнхий сайд нар Иж бүрэн түншлэлийн шинэ шатны нэг гол зорилт бол эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэх явдал гэж үзэв. Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагаа өнөөг хүртэл үндсэндээ Японы Засгийн газрын зээл, тусламжинд тулгуурлан явж ирсэн. Цаашид Японы зээл, тусламжийг манай улсын дэд бүтэц, боловсрол, хөдөөгийн хөгжил, байгаль орчны салбарт авч ашиглахын зэрэгцээ Японы хөрөнгө оруулалтыг дорвитой нэмэгдүүлэх замаар хувийн хэвшлийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах талаар

тохиролцлоо. Таван толгой, Оюу толгойн орд газруудыг Монгол Улсын том бүтээн байгуулалт болгон хөгжүүлэхэд, түүний дэд бүтцийг бий болгоход Японы томоохон компаниуд хөрөнгө оруулалт хийх санал тавьж Японы Засгийн газар түүнийг нь дэмжиж байгаа бөгөөд манай тал үнд бодлогын дэмжлэг үзүүлнэ гэдгийг тэмдэглээд Японы хөрөнгө оруулалтыг уул уурхайн салбараар хязгаарлахгүй бусад олон салбарт оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм.

Ерөнхий сайд Ж.Коизүми өнгөрсөн гуравдугаар сард Ерөнхий сайд М.Энхболдын санал хүсэлтийн дагуу Монгол Улсад олгох зээл, тусламжийн төслүүд, тухайлбал, олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих, Улаанбаатар хотын Энгельсийн гудамжны төмөр зам дээгүүрх гүүрэн замыг тавьж, хотын замыг сайжруулах гэх зэрэг төслүүдийг ажил хэргийн төвшинд судалж байгааг мэдэгдлээ. Ер нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд үр ашигтай нь нотлогдсон төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй гэдгээ Японы тал мэдэгдэв.

Эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжихийн сацуу хоёр орны ГХЯ, Сангийн яам, ҮХЯ, ХХААЯ, БОЯ-ны хооронд хийж эхэлсэн ажил хэргийн зөвлөлдөх уулзалтуудыг бэхжүүлэх, цаашдаа Засгийн газар хоорондын Комисс байгуулах асуудлыг авч үзэх шаардлагатай гэж талууд ярилцав. Мөн давхар татвараас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулах асуудлыг судлахаар тохиров.

Ерөнхий сайд М.Энхболд хэлэлцээний үеэр Ерөнхий сайд Ж.Коизүми-д хандан монголчуудын Япон улсад зорчих визийн журмыг хөнгөвчлөх асуудлыг шийдвэрлэхийг хүссэний дагуу анхааралдаа авч судлахаа мэдэгдэв.

Ерөнхий сайд Ж.Коизүми Монгол орны ирээдүй болсон хүүхэд залуусын боловсролыг дэмжих, Монгол, Японы харилцааны уламжлалыг залгамжилж авч явах залуу үеийг хүмүүжүүлэхэд анхаарал тавих ёстойг онцлон тэмдэглээд эдийн засгийн хамтын ажиллагааны төсөл “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр”-ийн ноот бичигт гарын үсэг зурав.

Энэ төслийн шугамаар Япон улсад, оюутан, аспирант сургахад 350 сая иен олгох ажээ. Мөн Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар арван аймгийн 10 сургуулийн хичээлийн болон дотуур байрыг засварлах тухайгаа мэдэгдэв. Ерөнхий сайд М.Энхболдын санал болгосны дагуу ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт оруулах япон үлгэр сонгож ирснээ гардуулав. Түүнчлэн япон хэл сурч

буй хүүхэд, залууст зориулан 800 толь бичгийн дээжсийг Ерөнхий сайдад гардуулсан.

Ерөнхий сайд нар хоёр орон олон улсын талбарт бие биеийг дэмжсэн хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, бүс нутгийн болон олон улсын чухал асуудлуудаар зөвлөлдөж байх нь зүйтэй гэж үзэж байгаагаа нотлов. Ерөнхий сайд Ж.Коизүми НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүнээр элсэх Япон улсын хүсэлтийг Монгол Улс дэмжиж ирсэнд талархал илэрхийлж, Монгол Улс АСЕМ-д элсэх хүсэлтийг Япон улс идэвхтэй дэмжиж буйгаа илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Ерөнхий сайд Ж.Коизүмиг найрсгаар хүлээн авч уулзаад Монгол оронд өрнөсөн ардчилал, шинэчлэлийн үйл явцыг эхнээс нь дэмжиж, хүнд хэцүү бэрх үед тусалж байсанд манай ард түмэн талархаж байдгийг илэрхийлэв. Мөн хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа иж бүрэн түншлэлийн хэмжээнд хүрч хөгжиж байгааг дурдсан юм. Энэ уулзалтаар бүс нутгийн асуудлуудаар санал солилцов.

Айлчлалын явцад Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан Ерөнхийлөгч Н.Энхбаярыг ирэх оны хоёрдугаар сард Япон улсад айлчлахыг, Монголд зохиох “Японы жил”-ийн хүндэт зочноор Японы эзэн хаан, хунтайж нарын хэн нэгнийг Монгол Улсад айлчлахыг харилцан урьсан юм. Мөн Японы Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Ё.Коно-г Монгол Улсад айлчлуулахаар урьсан юм.

Энэ онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Япон улсад Монголын жилийг тэмдэглэж, ирэх онд Монгол, Японы дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад Японы жилийг зохион байгуулах гэж байгаа нь хоёр ард түмэн бие биеийг улам сайн таньж мэдэх, ойртон дотносоход тустай гэдгийг нотолсон.

Ерөнхий сайд Ж.Коизүми найрсгаар хүлээн авч зочилсон Монгол Улсын төр, ард түмэнд талархлаа илэрхийлэв.

Ийнхүү хагас жилийн дотор хоёр улсын Засгийн газрын ерөнхий сайд нар харилцан айлчилсан явдал нь манай хоёр орны харилцаа улам бүр хөгжиж буйн баталгаа болж байна. Ерөнхий сайд М.Энхболд, Ж.Коизүми нарын 2006 оны гуравдугаар сард Токио хотноо хийсэн хэлэлцээ болон энэ удаагийн айлчлал нь Монгол, Японы харилцааны хүрсэн түвшинг нэгтгэн дүгнэж, цаашдын төлөв, тодруулан хэлбэл ойрын

10 жилийн төлвийг тодорхойлж өгсөн чухал ач холбогдолтой айлчлал, Монгол, Японы харилцааны түүхэнд тэмдэглэгдэн үлдэх томоохон үйл явдал боллоо.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. <http://www.mongolia-foreign-policy.net/>
2. <http://www.mn.emb-japan.go.jp>
3. “Олон Улс судлал” сэтгүүл, 2006, №2
4. Б.Сэржав “Монгол Японы харилцаа” УБ, 2003
5. “Ниппон ньюс” 2006, №42 (54)
6. “Зууны мэдээ” 2006-08-11, №192 (2328)
7. “Зууны мэдээ” 2006-08-14, №194 (2330)
8. “Өнөөдөр” 2006-08-11, №187 (2841)